


## **НҮБ-ЫН ЦӨЛЖИЛТТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ КОНВЕНЦЫН ТАЛУУДЫН 17 ДУГААР БАГА ХУРАЛ (UNCCD COP17)-ЫН НОГООН БҮСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ИВЭЭН ТЭТГЭГЧИЙН МЕНЕЖМЕНТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ОПЕРАТОР БАЙГУУЛЛАГЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР**

Энэхүү ажлын даалгавар нь Ногоон бүсийн барилга байгууламж, павильон, түр байгууламж, инженерийн түр хангамж, тоног төхөөрөмж болон холбогдох дэд бүтцийн ажлын цар хүрээтэй уялдуулан Ногоон бүсийн үйл ажиллагааны нэгдсэн менежмент, операторын зохион байгуулалт, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, ивээн тэтгэгчийн оролцоо, өдөр тутмын ашиглалт, үйлчилгээний зохион байгуулалтын тогтолцоог тодорхойлоход чиглэнэ.

### **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО**

Монгол Улсад зохион байгуулагдах НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх тухай конвенцын Талуудын 17 дугаар бага хурал (UNCCD COP17)-ын хүрээнд Ногоон бүсийг олон нийт, иргэний нийгэм, шинжлэх ухаан, хувийн хэвшил, олон улсын байгууллага, залуучууд, орон нутгийн иргэд зэрэг олон талын оролцоог нэгтгэсэн үзэсгэлэн, хэлэлцүүлэг, танин мэдэхүй, соёл, хамтын ажиллагааны нээлттэй талбар хэлбэрээр зохион байгуулахаар төлөвлөж байна.

**Зураг 1. Ногоон бүсийн ерөнхий төлөвлөлт**



Ногоон бүсийн хүрээнд үндэсний болон олон улсын үзэсгэлэнгийн павильон, шинжлэх ухаан, олон нийтийн павильон, хүлээн авалтын болон арга хэмжээний танхим, ажилчдын хоол, үйлчилгээний павильон, олон нийтийн нээлттэй орон зай, үйлчилгээ, амралтын хэсэг, мэдээлэл сурталчилгаа болон олон нийтийн оролцооны төрөл бүрийн үйл ажиллагаа нэгэн зэрэг зохион байгуулагдах тул тэдгээрийн өдөр зохион байгуулалт, оролцогч байгууллагуудын уялдаа холбоо, зочдын урсгал, талбай ашиглалт, дотоод зохион байгуулалтыг олон улсын арга хэмжээний шаардлагад нийцүүлэн нэгдсэн удирдлагаар хангах шаардлагатай байна.

Иймд энэхүү ажлын даалгаврын зорилго нь Ногоон бүсийн павильон борлуулалт, оролцогч байгууллагуудтай харилцах, захиалгат павильоны зураг төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах, холбогдох гүйцэтгэгч байгууллагуудыг сонгон шалгаруулж ажиллуулах, дотоод зөөлөн тохижилт, орчны зохион байгуулалт, өдөр тутмын үйл ажиллагааны уялдаа холбоо, талбайн бэлэн байдал, арга хэмжээний зохион байгуулалт, үйлчилгээний хэвийн ажиллагааг хангах, цэвэрлэгээ, хамгаалалт, техникийн үйлчилгээ болон хоол хүнсний үйлчилгээ үзүүлэх туслан гүйцэтгэгч байгууллагуудын өдөр тутмын ажлын зохион байгуулалт, уялдаа холбоог нэгдсэн байдлаар ханган ажиллах оператор байгууллагын зохион байгуулалт, менежментийн үйлчилгээний ажлын цар хүрээг тогтооход оршино.

## **ХОЁР. АЖЛЫН ЕРӨНХИЙ ХҮРЭЭ**

Энэхүү ажлын даалгаврын хүрээнд оператор байгууллага нь Ногоон бүсийн тодорхой хэсгийн бүтээн байгуулалт, өдөр тутмын ашиглалт, үйл ажиллагааны менежмент, оролцогч байгууллагуудын уялдаа холбоо, үйлчилгээний зохион байгуулалт болон арга хэмжээ дууссаны дараах буулгалт, талбайг хүлээлгэн өгөхтэй холбоотой дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Ногоон бүсийн үйл ажиллагааг хувийн хэвшлийн оролцоо, ивээн тэтгэгч, хамтран ажиллагч байгууллага, үзэсгэлэн гаргагч, үйлчилгээ эрхлэгчдийн оролцоонд тулгуурласан санхүүгийн болон үйл ажиллагааны загвараар хэрэгжүүлэх санал, төлөвлөгөө боловсруулах;
- Ивээн тэтгэгч, хамтран ажиллагч байгууллага, үндэсний болон олон улсын оролцогч, үзэсгэлэн гаргагч, худалдаа үйлчилгээ эрхлэгчдийг татан оролцуулах, тэдгээртэй холбоотой бүртгэл, гэрээ, үйлчилгээ, талбай ашиглалт, өдөр тутмын зохион байгуулалтыг хэрэгжүүлэх;
- Стандарт болон захиалгат павильоны зураг төсөл, дотоод зохион байгуулалт, угсралт, буулгалтын ажлыг зохион байгуулах;
- Ногоон бүсийн өдөр тутмын үйл ажиллагаа, хурал, хэлэлцүүлэг, үзэсгэлэн, соёл олон нийтийн арга хэмжээ, бүх төрлийн үйлчилгээ, хэвлэл мэдээлэл, сурталчилгаа, урсгалын зохион байгуулалт, техникийн ашиглалт, талбайн бэлэн байдал, шуурхай удирдлага болон холбогдох байгууллагуудын уялдаа холбоог нэгдсэн байдлаар хангах;
- Цэвэрлэгээ, хамгаалалт, техник үйлчилгээ, ложистик болон бусад туслан гүйцэтгэгч байгууллагуудын өдөр тутмын ажлын уялдаа холбоо, хяналт, зохион байгуулалтыг хэрэгжүүлэх;
- Ногоон бүсийн үйл ажиллагаатай холбоотой санхүү, өдөр тутмын үйл ажиллагаа, үйлчилгээ, аюулгүй ажиллагаа, эрсдэлийн нөхцөл байдал, оролцогч байгууллагуудын үйл ажиллагааны хэрэгжилтийн талаар тайлан, мэдээллийг тогтмол боловсруулж захиалагчид хүргүүлэх;
- Арга хэмжээ дууссаны дараа павильон, тоног төхөөрөмж, дотоод тохижилтын буулгалт, материалын зөөвөрлөлт, талбайн цэвэрлэгээ, нөхөн сэргээлт, хөрөнгө хүлээлцэх болон талбайг хэвийн нөхцөлд хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулах.

## **ГУРАВ. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, САНХҮҮГИЙН ЗАГВАР**

Гүйцэтгэгч нь Ногоон бүсийн түр байр байгууламж, үзэсгэлэнгийн павильон, тоног төхөөрөмж, инженерийн хангамж, дэд бүтэц, үйлчилгээ, өдөр тутмын үйл ажиллагааны зохион

байгуулалтад шаардагдах хөрөнгө оруулалтыг хувийн хэвшлийн оролцоо, ивээн тэтгэгч, хамтран ажиллагч байгууллага, оролцогчдын санхүүгийн эх үүсвэрт тулгуурлан хэрэгжүүлнэ. Энэ хүрээнд:

- Ногоон бүсийн барилга байгууламж, павильон, тайз, дотоод тохижилт, тоног төхөөрөмж, инженерийн түр хангамж, үйлчилгээ, өдөр тутмын үйл ажиллагааны менежментэд шаардагдах хөрөнгө оруулалтыг төрөөс шууд санхүүжилт шаардахгүйгээр хэрэгжүүлэх санхүүгийн загвар боловсруулж, орлого-зардлын тооцоо, мөнгөн урсгалын төсөөлөл, хөрөнгө оруулалтын өгөөж, санхүүгийн тогтвортой байдлын үнэлгээ, хэрэгжилтийн үе шат, оролцогч талуудын үүрэг, оролцооны механизмыг тодорхойлно. Мөн төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, хамтарсан хөрөнгө оруулалт болон ашиглалтын орлогод суурилсан хэрэгжүүлэх боломжит бүтцийг судалж, хөрөнгө оруулалтын эргэн төлөлтийн боломжийг тооцно.
- Стандарт болон захиалгат павильон, үзэсгэлэнгийн талбай, худалдаа үйлчилгээ, сурталчилгаа, идэвхжүүлэлтийн талбай, ивээн тэтгэгчийн багц, нэмэлт үйлчилгээ болон бусад холбогдох үйл ажиллагаанаас бүрдэх орлогын эх үүсвэр, үнэ тариф, үйлчилгээний багц, төлбөрийн бүтэц, ашиглалтын болон орлого бүрдүүлэх зохион байгуулалтын механизмыг боловсруулж хэрэгжүүлнэ.
- Гүйцэтгэгч нь санхүүжилт бүрдэхгүй байх, орлого тасалдах, оролцогч байгууллагын тоо буурах, ивээн тэтгэгч, хөрөнгө оруулагч болон хамтран ажиллагч байгууллагын оролцоо цуцлагдах, үйлчилгээний ачаалал нэмэгдэх, зардал өсөх, инфляц болон валютын ханшийн өөрчлөлтөөс үүсэх эрсдэлийг урьдчилан тооцож, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө, нөөц зохион байгуулалт, санхүүгийн хамгаалалтын арга хэмжээ болон үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах зохицуулалтыг боловсруулж, хэрэгжүүлнэ.
- Мөн захиалагчид үүсэж болзошгүй санхүүгийн эрсдэл, хариуцлага, нэмэлт зардал, төлбөрийн үүрэг, гэрээний хэрэгжилттэй холбоотой эрсдэлийг бууруулах зохион байгуулалтын арга хэмжээ, эрсдэлийн хуваарилалтын зарчим, санхүүгийн хяналт, тайлагнал, аудит болон хяналтын зохицуулалтыг тодорхой тусгасан санал ирүүлнэ.
- Санхүү, хөрөнгө оруулалтын загвар нь ил тод, бодитой хэрэгжих боломжтой байх бөгөөд орлого, зарлага, төлбөр тооцоо, гэрээний хэрэгжилт, орлогын хуваарилалт болон санхүүгийн тайлагналтыг хэрэгжүүлэхдээ COP17 зохион байгуулах Үндэсний хорооны Ажлын албаны “Дэд хороодын дэмжигч, түншлэгч татах ажлын хэсэг” болон Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэстэй хамтран хэрэгжүүлэх бөгөөд COP17-ийн “Хандив, тусламжийг төвлөрүүлэх, зарцуулах журам”-ыг баримтлан ажиллана.
- Гүйцэтгэгч нь үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхдээ болзошгүй гэнэтийн осол, аюулгүй ажиллагаа, олон нийтийн оролцоо болон үйлчилгээтэй холбоотой эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх бөгөөд ажилтан, гэрээт ажилтнууд болон гуравдагч этгээдэд учирч болзошгүй эд хөрөнгө, эрүүл мэндийн хохирлын эрсдэлийн даатгалын шаардлага, хамрах хүрээ, хариуцлагын зохицуулалтыг боловсруулж хэрэгжүүлнэ.

## **ДӨРӨВ. ИВЭЭН ТЭТГЭГЧ, ХАМТРАГЧ БАЙГУУЛЛАГА ТАТАН ОРОЛЦУУЛАХ**

Гүйцэтгэгч нь Ногоон бүсийн үйл ажиллагаанд ивээн тэтгэгч, хамтран ажиллагч байгууллага, үндэсний болон олон улсын оролцогч аж ахуйн нэгжүүдийг татан оролцуулах, хамтын

ажиллагааны бүтэц, ивээн тэтгэгчийн ангилал, үйлчилгээний нөхцөл, эрх үүрэг, хандивлагч, ивээн тэтгэгчдэд үзүүлэх үйлчилгээний багц, сурталчилгаа болон оролцооны нөхцөл, боломж, талбай ашиглалтын зохицуулалтын нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ.

Гүйцэтгэгч нь ивээн тэтгэгч болон хамтран ажиллагч байгууллагуудад зориулсан танилцуулга материал, хамтын ажиллагааны санал, үйлчилгээний багц, гэрээний төсөл, оролцооны нөхцөл, төлбөрийн санал болон холбогдох баримт бичгийг боловсруулж, захиалагчтай зөвшилцөн хэрэгжүүлнэ.

Түүнчлэн Ногоон бүсийн үзэл баримтлал, тогтвортой хөгжлийн зорилго, байгаль орчны чиглэлтэй уялдуулан ногоон технологи, сэргээгдэх эрчим хүч, усны менежмент, хог хаягдлын менежмент, нөхөн сэргээлт, мод үржүүлэг, тогтвортой үйлдвэрлэл, эко бүтээгдэхүүн, уур амьсгалын өөрчлөлтийн шийдэл, инновацын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудыг татан оролцуулах санал, хамтын ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, үнэ төлбөргүй павильон олгох ажлыг Ажлын албатай хамтран хэрэгжүүлнэ.

Гүйцэтгэгч нь ивээн тэтгэгч болон хамтран ажиллагч байгууллагуудаа сонгохдоо тэдгээр байгууллагуудын үйл ажиллагаа нь COP17 болон Ногоон бүсийн зорилго, НҮБ-ын үнэт зүйл, байгаль орчны бодлого, олон улсын арга хэмжээний нэр хүндтэй нийцсэн байх бөгөөд байгаль орчин, нийгэм, засаглалын хариуцлагын суурь шаардлагыг хангаагүй, улс төрийн шинжтэй сурталчилгаа явуулах, олон нийтийг төөрөгдүүлэх мэдээлэл түгээх, НҮБ болон COP17 арга хэмжээний нэр хүндэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй тохиолдолд тус байгууллагатай хамтран ажиллахгүй бөгөөд шаардлагатай тохиолдолд тэдгээрийн үйл ажиллагааны чиглэл, нэр хүнд, хууль эрх зүйн нөхцөл байдал, байгаль орчин, нийгмийн хариуцлага, засаглалын нөхцөл байдлын талаар нэмэлт мэдээлэл, нотлох баримт гаргуулан авч, эрсдэлийн үнэлгээ хийх зохион байгуулалтыг хэрэгжүүлнэ.

Ивээн тэтгэгчийн бодлого, албан ёсны түншлэлийн шийдвэр, НҮБ болон COP17 арга хэмжээний нэр, дүрс тэмдэг, нэгдсэн брэндийн бодлого, дипломат болон албан ёсны агуулгын зөвшөөрөл, баталгаажуулалтыг захиалагч талд танилцуулан, баталгаажуулсны үндсэн дээр хэрэгжүүлнэ.

## **ТАВ. ОПЕРАТОРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЕНЕЖМЕНТ**

Гүйцэтгэгч нь Ногоон бүсийн өдөр тутмын үйл ажиллагаа, хурал, хэлэлцүүлэг, үзэсгэлэн, соёл олон нийтийн арга хэмжээ, бүх төрлийн үйлчилгээ, хэвлэл мэдээлэл, сурталчилгаа, урсгалын зохион байгуулалт, техник ашиглалт, ложистик, цэвэрлэгээ, хамгаалалт талбайн бэлэн байдлыг шуурхай удирдлагаа хангаж ажиллах бөгөөд, холбогдох байгууллагуудын уялдаа холбоо, мэдээлэл солилцоо, хяналтыг хэрэгжүүлэх нэгдсэн удирдлагын төвийг зохион байгуулж ажиллана.

Энэ хүрээнд операторын удирдлагын бүтэц, багийн зохион байгуулалт, хүний нөөцийн төлөвлөлт, үүрэг хариуцлагын хуваарилалт, ээлжийн зохион байгуулалт, шуурхай удирдлагын тогтолцоо, өдөр тутмын ажлын уялдаа холбооны механизмыг боловсруулж хэрэгжүүлнэ.

Мөн гүйцэтгэгч нь стандарт болон захиалгат павильоны ангилал, байршил, хэмжээ, үйлчилгээний түвшин, үнэ тариф, ашиглалтын нөхцөл, үйлчилгээний багц, нэмэлт үйлчилгээний зохицуулалтыг боловсруулж, үндэсний болон олон улсын оролцогч

байгууллагуудад танилцуулах, борлуулах, гэрээ байгуулах, хэрэгжилтийг зохион байгуулах ажлыг хэрэгжүүлнэ.

Түүнчлэн захиалгат павильон хэрэгжүүлэхтэй холбоотой зураг төсөл, дотоод зохион байгуулалт, брэндиг, техникийн шийдэл, угсралт, буулгалтын ажлыг хэрэгжүүлэх гүйцэтгэгч байгууллагуудыг сонгон шалгаруулах, баталгаажуулах, тэдгээрийн уялдаа холбоо, талбайн нэвтрэх эрх, ашиглалт, техникийн шаардлага, хугацааны хэрэгжилтэд хяналт тавин ажиллана.

Мөн павильон эзэмшигч байгууллагуудад шаардлагатай тавилга, дотоод тохижилт, дэлгэц, дуу дүрс, гэрэлтүүлгийн тоног төхөөрөмжүүд, холбогдох техник хэрэгсэл болон хоол, хүнс зэрэг бусад нэмэлт үйлчилгээ үзүүлэх нийлүүлэгч байгууллагуудын нэгдсэн мэдээллийн сан, үйлчилгээний жагсаалт, түрээсийн нөхцөл, үнийн саналын зохион байгуулалтыг бүрдүүлж, оролцогч байгууллагуудын үйлчилгээний уялдаа холбоог ханган ажиллана.

Гүйцэтгэгч нь оролцогч байгууллага, үзэсгэлэн гаргагч, павильон эзэмшигч, үйлчилгээ эрхлэгчдийн бүртгэл, талбай хуваарилалт, гэрээ, нэвтрэх эрх, үйлчилгээний зохион байгуулалт, өдөр тутмын харилцаа холбоо, мэдээллийн дэмжлэг, асуудал шийдвэрлэлтийг хариуцан хэрэгжүүлнэ.

Түүнчлэн павильон, үзэсгэлэнгийн талбай, хүлээн авалтын танхим, арга хэмжээний танхим, кофе шоп, хоол үйлчилгээ, тайз, олон нийтийн бүс, амралтын хэсэг болон нийтийн эзэмшлийн талбайн өдөр тутмын ашиглалт, дотоод зохион байгуулалт, үйлчилгээний журмыг холбогдох Хоол хүнсний дэд хороотой хамтран боловсруулж мөрдүүлнэ.

Гүйцэтгэгч нь цахилгаан, интернэт, дуу дүрс, гэрэлтүүлэг, агааржуулалт, ус, ариун цэвэр, хог хаягдал, инженерийн түр хангамж болон техник ашиглалттай холбоотой эвдрэл, гэмтэл, саатал, хэвийн бус нөхцөл байдлыг шуурхай шийдвэрлэх техникийн болон зохион байгуулалтын бэлэн байдлыг хангаж ажиллана.

Мөн төлөөлөгчид, хүндэт зочид, хэвлэл мэдээллийнхэн, оролцогч байгууллагууд, үйлчилгээний ажилтнууд, нийлүүлэгчид, туслан гүйцэтгэгчид болон бусад холбогдох оролцогчдын бүртгэл, мэдээллийн сан, нэвтрэх ангилал, нэвтрэх үнэмлэх, нэвтрэх эрхийн зохион байгуулалтыг хэрэгжүүлж, ачаа бараа нэвтрүүлэх, буулгалт, үйлчилгээний тээврийн хөдөлгөөн, түр зөвшөөрөл болон талбай ашиглалтын уялдаа холбоог холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна. Аюулгүй байдлын шалган нэвтрүүлэх хяналт, техник хэрэгслийн хяналт, биет хамгаалалтын үйл ажиллагааг холбогдох аюулгүй байдлын баг хэрэгжүүлнэ.

Түүнчлэн өдөр тутмын үйл ажиллагааны бэлэн байдал, талбай ашиглалтын нөхцөл байдал, үйлчилгээний хэвийн ажиллагаа, гарсан асуудал, эрсдэлийн нөхцөл байдал, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар тогтмол тайлан, мэдээллийг боловсруулж захиалагчид хүргүүлнэ.

Арга хэмжээний хугацаанд павильон, дотоод тохижилт, техник хэрэгсэл, үйлчилгээний бүсүүдийн ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах үзлэг, засвар, шуурхай үйлчилгээний зохион байгуулалтыг хэрэгжүүлнэ.

Цэвэрлэгээ, хамгаалалт, техник үйлчилгээ болон бусад туслан гүйцэтгэгч байгууллагууд нь гэрээний үндсэн дээр тус тусын чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд гүйцэтгэгч нь тэдгээрийн өдөр тутмын ажлын уялдаа холбоо, зохион байгуулалт, хяналтыг нэгдсэн байдлаар хангаж ажиллана.

Сайн дурын ажилтнууд, техникийн болон үйлчилгээний ажилтнуудын өдөр тутмын хуваарь, байрлал, мэдээлэл хүргэлт, үйлчилгээний уялдаа холбоо, талбайн зохион байгуулалттай холбоотой зохицуулалтыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

Оператор нь зочдын санал, хүсэлт, гомдол, мэдээлэл, алдагдсан эд зүйлтэй холбоотой өдөр тутмын үйлчилгээ, бүртгэл, шийдвэрлэлтийн зохион байгуулалтыг хэрэгжүүлнэ.

Өдөр тутмын үйл ажиллагааны мэдээлэл, зочдын тоо, павильон ашиглалт, арга хэмжээний хэрэгжилт, гарсан асуудал, үйлчилгээний үзүүлэлт, оролцогч байгууллагын мэдээллийг нэгтгэсэн шуурхай тайлагнал, мэдээллийн хяналтын тогтолцоог хэрэгжүүлнэ.

Оператор байгууллага нь Ногоон бүсийн өдөр тутмын үйл ажиллагааны гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (KPI)-ийг боловсруулж, үйлчилгээний түвшин, зочдын сэтгэл ханамж, павильон ашиглалт, техникийн бэлэн байдал, аюулгүй ажиллагаа, тайлагналын хэрэгжилт болон шуурхай ажиллагааны үзүүлэлтүүдийг тогтмол хэмжиж, захиалагчид тайлагнаж ажиллана.

Гүйцэтгэгч нь Ногоон бүсийн үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй иргэн, өндөр настан, хүүхэд, олон улсын оролцогч болон олон нийт саадгүй, тэгш, хүртээмжтэй оролцох нөхцөлийг хангана. Энэ хүрээнд саадгүй зорчих маршрут, налуу зам, хүртээмжтэй үйлчилгээний цэг, хүртээмжтэй ариун цэврийн байгууламж, хөдөлгөөний зохион байгуулалт, олон хэл дээрх мэдээлэл, чиглүүлэх тэмдэглэгээ, мэдээллийн дэмжлэг болон оролцогчдод ойлгомжтой, хүртээмжтэй орчны шийдлийг холбогдох стандарт, шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлнэ.

Арга хэмжээ дууссаны дараа павильон, түр байгууламж, тоног төхөөрөмж, дотоод тохижилт, инженерийн түр хангамж болон бусад ашигласан эд хөрөнгийн бүртгэл, тооллого, хүлээлцэх ажлыг зохион байгуулж, эвдрэл, гэмтэл, дутуу хүлээлгэн өгсөн нөхцөл байдалд үнэлгээ хийж, холбогдох тайлан, акт, нөхөн төлбөрийн зохицуулалтыг хэрэгжүүлнэ.

Мөн талбай ашиглалт, байгууламжийн буулгалт, цэвэрлэгээ, нөхөн сэргээлт, техникийн болон ашиглалтын нөхцөл байдалтай холбоотой эцсийн үзлэг, шалгалт, хүлээн авах ажиллагааг захиалагч болон холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж, эцсийн хүлээлгэн өгөх баримт бичгийг боловсруулан баталгаажуулна

Павильон эзэмшигч, үйлчилгээ эрхлэгч болон арга хэмжээний хэрэгцээнд зориулсан түр хадгалалтын бүс, материал хадгалалт, түр агуулах ашиглалтын зохион байгуулалтыг хэрэгжүүлнэ.

Павильон, брэндиг, хаягжуулалт, дотоод тохижилт, хэвлэмэл материал болон олон нийтэд харагдах орчны үндсэн элементүүдийн жишиг загвар, дээж, туршилтын хувилбарыг боловсруулж, захиалагчийн баталгаажуулалтын үндсэн дээр хэрэгжүүлнэ.

## **ЗУРГАА. ХӨТӨЛБӨР, КОНТЕНТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

Гүйцэтгэгч нь Ногоон бүсийн үндсэн тайз, үзэсгэлэнгийн талбай, олон нийтийн оролцооны бүс, шинжлэх ухаан болон хэлэлцүүлгийн орчинд зохион байгуулагдах өдөр тутмын арга хэмжээ, танилцуулга, хэлэлцүүлэг, сургалт, соёл урлаг, олон нийтийн оролцооны хөтөлбөрүүдийн зохион байгуулалт, хэрэгжилтийн нэгдсэн төлөвлөгөө боловсруулж ирүүлнэ.

Энэ хүрээнд Ногоон бүсийн нээлт, хаалт, өдөр тутмын үндсэн арга хэмжээ, хэлэлцүүлэг, сургалт, танилцуулга, практик уулзалт, шинжлэх ухаан, олон нийтийн оролцооны арга хэмжээ, үзэсгэлэн, соёл урлагийн тоглолт, үзэсгэлэн, танилцуулга, тусгай арга хэмжээний ерөнхий

бүтэц, цагийн хуваарь, хөдөлгөөний схем, техникийн хэрэгцээ, тайзны зохион байгуулалт, талбай ашиглалтын уялдаа холбоо, зохион байгуулалтын хийж ажиллана.

Мөн цөлжилт, газрын доройтол, уур амьсгалын өөрчлөлт, бэлчээр, усны нөөц, сэргээгдэх эрчим хүч, хог хаягдлын менежмент, тогтвортой хот, ногоон хөгжил, байгаль хамгаалал, шинжлэх ухаан, инновац, залуучуудын оролцоо болон олон нийтийн боловсролын чиглэлээр зохион байгуулах сэдэвчилсэн арга хэмжээ, танилцуулга, олон нийтийн оролцооны хөтөлбөрийн санал боловсруулна.

Мөн орчуулга, дуу, дүрс, гэрэлтүүлэг, дэлгэц, бичлэг, шууд дамжуулалт, хэвлэл мэдээллийн техникийн уялдаа холбоо, тайзны техникийн бэлэн байдал, хөтөлбөр хоорондын шилжилт, өдөр тутмын ажиллагааны зохион байгуулалтыг нэгдсэн байдлаар хэрэгжүүлнэ.

Хүндэт зочид, олон улсын төлөөлөгч, албан ёсны арга хэмжээтэй холбоотой зохион байгуулалтыг протокол хариуцсан холбогдох байгууллагуудтай уялдуулан хэрэгжүүлнэ.

Хөтөлбөр, арга хэмжээний зохион байгуулалтын хүрээнд гүйцэтгэгч нь арга хэмжээний зохион байгуулалт, техникийн хэрэгжилт, өдөр тутмын уялдаа холбоо, талбай ашиглалтын менежментийг хэрэгжүүлэх бөгөөд НҮБ болон COP17 арга хэмжээний албан ёсны бодлогын агуулга, дипломат шинжтэй байр суурь, үндсэн хөтөлбөрийн баталгаажуулалт, албан ёсны контентын зөвшөөрлийг захиалагч тал хариуцна.

## **ДОЛОО. ХУДАЛДАА, ХООЛ ҮЙЛЧИЛГЭЭ, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДИЙН ЗОХИЦУУЛАЛТ**

Гүйцэтгэгч нь Ногоон бүсийн хүрээнд ажиллах хоол, ундаа, кофе шоп, худалдаа үйлчилгээ, түр үйлчилгээний цэг, олон нийтэд үйлчлэх үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын байршил, өдөр тутмын үйл ажиллагаа, үйлчилгээний стандарт, уялдаа холбооны зохион байгуулалтыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.

- Энэ хүрээнд хоол үйлчилгээ, кофе шоп, худалдаа үйлчилгээ, түр үйлчилгээний цэг ажиллуулах байгууллагуудын талбай ашиглалтын нөхцөл, үйл ажиллагааны цагийн хуваарь, дотоод зохион байгуулалтын журмыг боловсруулна.
- Мөн үйлчилгээний стандарт, дарааллын зохицуулалт, үйлчилгээний чанар, гомдол шийдвэрлэлтийн зохион байгуулалтын нөхцөлийг тодорхойлж хэрэгжүүлнэ.
- Түүнчлэн хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуй, зөвшөөрөл, бүтээгдэхүүний хадгалалт, дээж хадгалалт, хүнсний гарал үүслийн бүртгэл, ариун цэвэр, цэвэрлэгээ, ус хангамж, хог хаягдлын менежмент, өдөр тутмын хяналтын шаардлагыг мөрдүүлж ажиллана.
- Гүйцэтгэгч нь нэг удаагийн хуванцар хэрэглээг бууруулах, дахин ашиглах боломжтой сав баглаа боодол ашиглах, ангилан ялгах хогийн сав байрлуулах, хог хаягдлыг ангилан ялгах, хүнсний хаягдлыг бууруулах, байгаль орчинд ээлтэй хэрэглээ, ногоон үйлчилгээний шаардлагыг мөрдүүлэх зохион байгуулалтыг хэрэгжүүлнэ.
- Мөн худалдаа үйлчилгээний талбайн байршил, урсгалын зохион байгуулалт, цахилгаан, ус, интернэт, ариун цэврийн болон инженерийн түр хангамжийн уялдаа холбоо, ачаа буулгалт, нийлүүлэлтийн цагийн зохицуулалт, үйлчилгээний бүсүүдийн өдөр тутмын бэлэн байдлыг хангаж ажиллана.
- Түүнчлэн худалдаа үйлчилгээний орлого, түрээс, үйлчилгээний шимтгэл, ивээн тэтгэгч болон хамтран ажиллагч байгууллагын нөхцөлтэй уялдсан санхүүгийн зохицуулалт, төлбөрийн бүтэц, орлого хуваарилалтын санал боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулна.

- Гүйцэтгэгч нь худалдаа үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын өдөр тутмын үйл ажиллагаа, үйлчилгээний чанар, эрүүл ахуй, аюулгүй байдал, хэрэглэгчийн үйлчилгээ, байгаль орчны шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, илэрсэн зөрчил, эрсдэлийг шуурхай шийдвэрлэх зохион байгуулалтыг хэрэгжүүлнэ.

## **НАЙМ. БРЭНДИНГ, МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦАА, СУРТАЛЧИЛГАА**

Гүйцэтгэгч нь Ногоон бүсийн нэгдсэн өнгө төрх, орон зайн мэдээлэл, брэндинг, сурталчилгаа, олон нийтэд хүргэх мэдээлэл, дотоод болон гадаад харилцааны зохион байгуулалтыг Ногоон бүсийн ерөнхий төлөвлөлт, COP17-ын зорилго, НҮБ-ын үнэт зүйл болон байгаль орчны үзэл баримтлалтай уялдуулан хэрэгжүүлэх санал боловсруулж ирүүлнэ.

- Энэ хүрээнд Ногоон бүсийн нэгдсэн дизайн, өнгө төрх, дотоод болон гадна орчны хаягжилт, чиглүүлэх тэмдэглэгээ, газрын зураг, мэдээллийн самбар, павильон болон үйлчилгээний бүсүүдийн таних тэмдэг, зочдын урсгал чиглүүлэх шийдэл, олон нийтийн мэдээллийн орчны зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулна.
- Мөн павильон, тайз, үзэсгэлэнгийн талбай, нийтийн эзэмшлийн бүс, хэвлэл мэдээллийн орчин, үйлчилгээний хэсэг болон ивээн тэтгэгчийн брэндинг байршуулах орчны зохион байгуулалт, харагдах орчин, хэмжээ, байршил, давтамж, хэрэгжүүлэх болон хориглох нөхцөл, нэгдсэн дизайны шаардлагыг тодорхойлно.
- Түүнчлэн Ногоон бүсийн цахим мэдээлэл, олон нийттэй харилцах, сурталчилгааны төлөвлөгөө боловсруулж, цахим хуудас, олон нийтийн сүлжээ, QR мэдээллийн систем, дижитал дэлгэц, шууд дамжуулалт, хэвлэл мэдээллийн сувгаар мэдээлэл түгээх зохион байгуулалтын санал боловсруулна.
- Гадаад, дотоодын зочид, оролцогч байгууллага, хэвлэл мэдээлэл болон олон нийтэд зориулсан танилцуулга материал, өдөр тутмын хөтөлбөр, талбайн зураг, үйлчилгээний зааварчилгаа, хөдөлгөөний схем, аюулгүй ажиллагааны мэдээлэл болон бусад шаардлагатай мэдээллийн материалыг бэлтгэх, түгээх зохион байгуулалтыг төлөвлөнө.
- Мөн Ногоон бүсийн хүрээнд хэрэгжүүлэх сурталчилгаа, мэдээлэл харилцаа, брэндинг, олон нийттэй харилцах үйл ажиллагаа нь COP17-ын зорилго, Ногоон бүсийн нэр хүнд, НҮБ-ын үнэт зүйл, байгаль орчны бодлого, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтай нийцсэн байх бөгөөд улс төрийн шинжтэй сурталчилгаа, олон нийтийг төөрөгдүүлэх мэдээлэл, үндэслэлгүй “ногоон” сурталчилгаа болон НҮБ, COP17-ын нэр хүндэд сөргөөр нөлөөлөх агуулгыг хориглоно.
- Гүйцэтгэгч нь брэндинг, мэдээлэл харилцаа, сурталчилгааны өдөр тутмын хэрэгжилт, талбай ашиглалтын уялдаа холбоо, мэдээллийн самбар, дижитал мэдээллийн систем, хэвлэл мэдээллийн зохион байгуулалтын хэвийн ажиллагааг хангаж ажиллана.
- Хэвлэл мэдээллийн төлөөлөгчдийн ажиллах орчин, ярилцлага авах хэсэг, зураг авалтын цэг, шууд дамжуулалтын байршил, хэвлэл мэдээллийн хөдөлгөөний зохион байгуулалт, өдөр тутмын мэдээллийн дэмжлэгийн уялдаа холбоог хангаж ажиллана.
- Павильон, тоног төхөөрөмж, түр байгууламж, дотоод тохижилттой холбоотой ашиглалтын нөхцөл, хариуцлагын зохицуулалт, эвдрэл гэмтлийн нөхөн төлбөр, барьцаа болон хүлээлцэх журмын зохион байгуулалтын саналыг боловсруулан батлуулж, хэрэгжүүлнэ.

## **ЕС. АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЗӨВШӨӨРӨЛ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА**

Гүйцэтгэгч нь Ногоон бүсийн бүтээн байгуулалт, өдөр тутмын үйл ажиллагаа, үзэсгэлэн, арга хэмжээ, үйлчилгээ болон олон нийтийн оролцооны бүхий л үйл ажиллагааны үеийн аюулгүй ажиллагаа, эрсдэлийн удирдлага, шуурхай хариу арга хэмжээний зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ.

- Энэ хүрээнд галын аюулгүй байдал, нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө, аврах гарц, ослын үеийн хөдөлгөөний схем, аюулгүй ажиллагааны тэмдэглэгээ, мэдээллийн самбар, гал унтраах хэрэгсэл, усан хангамж, галын дохиолол, анхааруулах системийн байршлын зураглал, өдөр тутмын шалгалт, бэлэн байдлын зохион байгуулалтыг боловсруулна.
- Мөн цагдаа, хамгаалалт, шалган нэвтрүүлэх цэг, ачаа болон тоног төхөөрөмжийн хяналт, олон нийтийн урсгалын зохицуулалт, хүндэт зочид болон тусгай хамгаалалттай оролцогчдын хөдөлгөөний зохион байгуулалт, олон хүн төвлөрөх нөхцөлд авах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ.
- Түүнчлэн эмнэлгийн анхан шатны тусламжийн цэг, түргэн тусламжийн бэлэн байдал, яаралтай үед ажиллах холбоо, мэдээлэл солилцоо, осол гэмтэл, эрүүл мэндийн эрсдэлийн үед авах арга хэмжээний зохион байгуулалтыг холбогдох байгууллагуудтай хамтран төлөвлөнө.
- Гүйцэтгэгч нь салхи, бороо, шороо, үер ус, агаарын чанарын доройтол, цахилгааны тасалдал, интернэтийн саатал, инженерийн түр хангамжийн доголдол, тоног төхөөрөмжийн эвдрэл, хүнсний аюулгүй байдал, олны хөл хөдөлгөөн, гал түймэр болон бусад болзошгүй эрсдэлийн үед хэрэгжүүлэх шуурхай хариу арга хэмжээ, нөөц төлөвлөгөө, техникийн болон зохион байгуулалтын бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.
- Мөн эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, бүртгэх, ангилах, хяналт тавих, шат дараалсан мэдээлэл дамжуулах, холбогдох байгууллагуудтай хамтран шуурхай шийдвэрлэх зохион байгуулалтын тогтолцоог бүрдүүлнэ.
- Түүнчлэн Ногоон бүсийн бүтээн байгуулалт, түр байгууламж, павильон, үзэсгэлэн, үйлчилгээ, арга хэмжээ болон өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой шаардлагатай зөвшөөрөл, дүгнэлт, техникийн нөхцөл, хяналт шалгалт, аюулгүй ажиллагааны шаардлагын уялдаа холбоог хангах хүрээнд холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж, захиалагчид шаардлагатай дэмжлэг үзүүлнэ.
- Гүйцэтгэгч нь өдөр тутмын аюулгүй ажиллагааны үзлэг, эрсдэлийн үнэлгээ, осол зөрчлийн бүртгэл, тайлагнал, шуурхай удирдлагын зохион байгуулалтыг хэрэгжүүлж, гарсан асуудал, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар захиалагчид тогтмол мэдээлж ажиллана.
- Цаг агаарын онцгой нөхцөл үүссэн үед павильон, тайз, түр байгууламж, олон нийтийн талбайн ашиглалтыг хэсэгчлэн эсхүл түр хугацаагаар зохицуулах, аюулгүй бүс рүү шилжүүлэх, үйл ажиллагааны өөрчлөлтийн мэдээллийг шуурхай хүргэх зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулна.
- Павильон болон үйлчилгээний талбайн цахилгаан, интернэт, ус, нэмэлт техникийн үйлчилгээний хэрэглээ, нэмэлт ачаалалтай холбоотой ашиглалтын нөхцөл, төлбөрийн зохицуулалтын санал боловсруулна.
- Түр байгууламж, тайз, павильон, цахилгаан болон техникийн угсралттай холбоотой шаардлагатай аюулгүй ажиллагаа, бүтээц, ашиглалтын дүгнэлт, баталгаажуулалтын уялдаа холбоог хангаж ажиллана.

## **АРАВ. НОГООН ШААРДЛАГА, ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗАРЧИМ**

Гүйцэтгэгч нь Ногоон бүсийн бүтээн байгуулалт, өдөр тутмын үйл ажиллагаа, үйлчилгээ, арга хэмжээний зохион байгуулалт болон талбай ашиглалтын бүхий л үе шатанд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, нөөцийн зохистой хэрэглээг дэмжих, тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийн зарчмыг хэрэгжүүлэх санал, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.

- Энэ хүрээнд хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, дахин боловсруулах боломжтой хаягдлын урсгалыг тусгаарлах, хүнсний болон ахуйн хаягдлын зохистой менежментийг хэрэгжүүлэх, хог хаягдлын өдөр тутмын цэвэрлэгээ, тээвэрлэлт, түр хадгалалт, хяналтын тогтолцоог бүрдүүлнэ.
- Мөн нэг удаагийн хуванцар хэрэглээг бууруулах, дахин ашиглах боломжтой сав баглаа боодол, байгальд ээлтэй материал, олон дахин угсарч ашиглах боломжтой хийц, тоноглол, модульчлагдсан шийдэл, дахин ашиглах боломжтой дотоод тохижилт, тавилга, үйлчилгээний хэрэгслийг ашиглах зохион байгуулалтыг хэрэгжүүлнэ.
- Түүнчлэн эрчим хүч, усны хэрэглээг бууруулах, үр ашигтай ашиглах, бага зарцуулалттай тоног төхөөрөмж, гэрэлтүүлэг, усны хэмнэлттэй шийдэл, сэргээгдэх эрчим хүч болон байгаль орчинд ээлтэй технологи ашиглах боломжит хувилбар, зохион байгуулалтын арга хэмжээг санал болгож хэрэгжүүлнэ.
- Гүйцэтгэгч нь Ногоон бүсийн хүрээнд ашиглагдах барилга байгууламж, павильон, үйлчилгээ, худалдаа, хоол үйлчилгээ, арга хэмжээний зохион байгуулалт, сурталчилгаа, хэвлэл мэдээлэл, ложистик болон бусад үйл ажиллагаанд байгаль орчны шаардлага, тогтвортой байдлын зарчмыг мөрдүүлэх хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлнэ.
- Ногоон бүсийн үйл ажиллагааны хүрээнд үүссэн хог хаягдал, дахин ашиглалт, ус болон эрчим хүчний хэрэглээ, байгаль орчны нөлөөллийн үндсэн үзүүлэлтүүдийг хэмжих, нэгтгэх, тайлагнах, тогтвортой байдлын үндсэн шалгуур үзүүлэлт (KPI)-ийг тогтоон хэрэгжилтийг үнэлэх зохион байгуулалтыг хэрэгжүүлнэ.
- Мөн оролцогч байгууллага, үйлчилгээ эрхлэгч, ивээн тэтгэгч, туслан гүйцэтгэгч байгууллагуудад байгаль орчинд ээлтэй хэрэглээ, хог хаягдлын менежмент, эрчим хүчний зохистой хэрэглээ, ногоон үйлчилгээний шаардлагыг мөрдүүлэх зохион байгуулалтыг ханган ажиллана.
- Арга хэмжээ дууссаны дараа түр байгууламж, павильон, тоног төхөөрөмж, дотоод тохижилт, инженерийн түр хангамж болон бусад ашигласан материал, байгууламжийг аюулгүй, зохистой буулган зайлуулах, дахин ашиглах боломжтой эд зүйлсийг ангилан шилжүүлэх, талбайг цэвэрлэж, бохирдолгүй, аюулгүй, хэвийн нөхцөлд оруулан хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулна.
- Ногоон бүсийн хүрээнд ашигласан павильон, түр байгууламж, тоног төхөөрөмж, материалын дахин ашиглалт, шилжүүлэн ашиглах боломж, цаашдын хэрэглээ, урт хугацааны ашиглалтын шийдлийг тусгасан төлөвлөгөө боловсруулж, түр байгууламж, модульчлагдсан хийц, дахин ашиглах боломжтой дотоод тохижилт, тоноглолын үр ашигтай хэрэглээг дэмжин ажиллана.
- Мөн арга хэмжээ дууссаны дараах байгаль орчин, тогтвортой байдлын хэрэгжилтийн тайлан боловсруулж, хог хаягдал, дахин ашиглалт, эрчим хүч, усны хэрэглээ, нүүрстөрөгчийн ялгарал бууруулахтай холбоотой хэрэгжилтийн үзүүлэлт, үр дүнг нэгтгэн тайлагнана.
- Түүнчлэн Ногоон бүсийн нэр, зорилго, НҮБ болон COP17-ын байгаль орчны бодлого, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтай нийцүүлэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, нөөцийн үр ашигтай хэрэглээг дэмжих, олон нийтэд эерэг нөлөө үзүүлэх тогтвортой байдлын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.

## **АРВАН НЭГ. ГҮЙЦЭТГЭГЧИД ТАВИХ ШААРДЛАГА**

Гүйцэтгэгч нь олон улсын болон үндэсний хэмжээний олон нийтийн арга хэмжээ, үзэсгэлэн, павильон, хурал, форум, соёл, олон нийтийн арга хэмжээний зохион байгуулалт, операторын менежмент, үйлчилгээ, талбай ашиглалт, түр байгууламж, тайз, техникийн болон өдөр тутмын үйл ажиллагааны зохион байгуулалт хэрэгжүүлж байсан туршлагатай байна.

- Мөн гүйцэтгэгч нь Ногоон бүсийн үйл ажиллагааг хувийн хэвшлийн оролцоо, ивээн тэтгэгч, хамтран ажиллагч байгууллага, оролцогч байгууллагуудын санхүүгийн эх үүсвэрт тулгуурлан хэрэгжүүлэх бодит чадавх, туршлага, хамтын ажиллагааны сүлжээтэй байх бөгөөд хөрөнгө оруулалт татах, ивээн тэтгэгчтэй хамтран ажиллах, үйлчилгээний орлого бүрдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн өмнөх туршлагын мэдээлэл ирүүлнэ.
- Гүйцэтгэгч нь барилга байгууламж, түр байгууламж, инженерийн түр хангамж, цахилгаан, интернэт, мэдээлэл холбоо, дуу дүрс, гэрэлтүүлэг, дэлгэц, тайз, аюулгүй ажиллагаа, ложистик, худалдаа үйлчилгээ, хэвлэл мэдээлэл, олон нийтийн арга хэмжээний зохион байгуулалтын чиглэлээр мэргэжлийн баг болон гэрээт түнш байгууллагуудтай байна.
- Түүнчлэн удирдлагын бүтэц, хэрэгжүүлэх багийн бүрэлдэхүүн, үндсэн мэргэжилтнүүдийн туршлага, хүний нөөцийн төлөвлөлт, өдөр тутмын ажиллагааны зохион байгуулалт, шуурхай удирдлагын бүтэц, гэрээт түнш байгууллагуудын мэдээлэл, хамтын ажиллагааны механизмыг тодорхой тусгасан санал ирүүлнэ.
- Гүйцэтгэгч нь санхүүгийн чадавх, өмнөх төслүүдийн туршлага, хэрэгжүүлэх аргачлал, санхүүгийн загвар, хөрөнгө оруулалтын бүтэц, эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө, хэрэгжилтийн үе шат, хугацааны график, өдөр тутмын үйл ажиллагааны зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулж ирүүлнэ.
- Мөн захиалагчийн баталсан ерөнхий төлөвлөгөө, зураг төсөл, талбайн зохион байгуулалт, барилга байгууламжийн ажлын даалгавар, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, инженерийн түр хангамж болон олон улсын арга хэмжээний холбогдох шаардлагуудтай уялдуулан ажиллах чадавхтай байна.
- Гүйцэтгэгч нь НҮБ болон COP17 арга хэмжээний нэр хүнд, дипломат шинж чанар, олон улсын арга хэмжээний онцлогт нийцүүлэн ажиллах бөгөөд нууцлал, мэдээллийн аюулгүй байдал, олон нийттэй харилцах болон албан ёсны агуулгатай холбоотой захиалагчийн шаардлагыг мөрдөнө.
- Гүйцэтгэгч нь COP17 арга хэмжээнд нэн түрүүнд шаардлагатай бүтээгдэхүүн, дагалдах хэрэгсэл/Хавсралтад заасан/ бэлэн байна.
- Гүйцэтгэгч нь арга хэмжээг түншлэлээр хамтран болон туслан гүйцэтгэгчтэй хамтарч болно.

## **АРВАН ХОЁР. ИРҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ, ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ ҮР ДҮН**

Энэхүү ажлын даалгаврын хүрээнд ирүүлэх баримт бичиг, санал, төлөвлөгөө нь Ногоон бүсийн бүтээн байгуулалт, үйл ажиллагааны менежмент, санхүүгийн тогтвортой байдал, оролцогч байгууллагуудын уялдаа холбоо, үйлчилгээний зохион байгуулалт, аюулгүй ажиллагаа, байгаль орчны шаардлага болон өдөр тутмын ашиглалтын бэлэн байдлыг иж бүрнээр тодорхойлсон байна.

Гүйцэтгэгч нь доорх баримт бичиг, төлөвлөгөө, тайлан, зохион байгуулалтын материалыг боловсруулж ирүүлэх бөгөөд эдгээр нь Ногоон бүсийн үйл ажиллагааг олон улсын арга

хэмжээний түвшинд хэрэгжүүлэхэд шаардлагатай удирдлага, зохион байгуулалт, санхүү, үйлчилгээ, техникийн болон үйл ажиллагааны шийдлийг бүрэн тусгасан байна.

№	Ирүүлэх материал	Тайлбар
1	Ногоон бүсийн операторын ерөнхий концепц	Ногоон бүсийн нэгдсэн үйл ажиллагааны загвар, хэрэгжүүлэх аргачлал, удирдлагын бүтэц, операторын үүрэг хариуцлага, өдөр тутмын зохион байгуулалт, үйлчилгээний ерөнхий төлөвлөлт
2	Хөрөнгө оруулалт, санхүүгийн загвар	Зардал, орлого, хөрөнгө оруулалтын бүтэц, санхүүжилтийн эх үүсвэр, мөнгөн урсгал, орлого-зардлын тооцоо, эрсдэлийн удирдлага, орлого бүрдүүлэх механизм, хэрэгжилтийн үе шат
3	Ивээн тэтгэгч, хамтран ажиллагч байгууллагын санал	Ивээн тэтгэгчийн ангилал, үйлчилгээний багц, оролцооны түвшин, сурталчилгаа, брэндинг, ESG болон нэр хүндийн шалгуур, хамтын ажиллагааны санал
4	Павильон борлуулалт, үнэ тариф болон коммерс төлөвлөгөө	Стандарт болон захиалгат павильоны ангилал, хэмжээ, байршил, үнэ тариф, үйлчилгээний багц, борлуулалтын стратеги, төлбөрийн нөхцөл, орлого бүрдүүлэх механизм, павильон ашиглалтын журам
5	Захиалгат павильон хэрэгжилт болон exhibitor үйлчилгээний төлөвлөгөө	Захиалгат павильоны зураг төсөл, дотоод зохион байгуулалт, брэндинг, угсралт, буулгалтын зохион байгуулалт, гүйцэтгэгч байгууллагын сонгон шалгаруулалт, хяналт, оролцогч байгууллагын үйлчилгээний зохицуулалт
6	Нийлүүлэгч болон нэмэлт үйлчилгээний менежментийн төлөвлөгөө	Тавилга, AV/ICT, дуу дүрс, гэрэлтүүлэг, техник хэрэгсэл, дотоод тохижилт, хоол үйлчилгээ болон бусад нэмэлт үйлчилгээ нийлүүлэгч байгууллагуудын лист, үйлчилгээний жагсаалт, түрээсийн нөхцөл, үнийн санал, үйлчилгээний зохицуулалт
7	Үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөө	Өдөр тутмын хөтөлбөр, үзэсгэлэн, тайз, үйлчилгээ, олон нийтийн оролцоо, урсгалын зохион байгуулалт, талбай ашиглалт, шуурхай удирдлагын зохион байгуулалтын төлөвлөгөө
8	Операторын бүтэц, хүний нөөцийн төлөвлөгөө	Удирдлагын бүтэц, багийн бүрэлдэхүүн, үндсэн мэргэжилтнүүд, хүний нөөцийн төлөвлөлт, ээлжийн зохион байгуулалт, command center болон шуурхай удирдлагын тогтолцоо
9	Аюулгүй байдал, эрсдэлийн удирдлага	Галын аюулгүй байдал, нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө, эрсдэлийн үнэлгээ, шуурхай хариу арга хэмжээ, олон нийтийн хариуцлагын даатгал, event liability, тоног

	болон даатгалын төлөвлөгөө	төхөөрөмж болон үйл ажиллагааны эрсдэлийн хамгаалалтын зохицуулалт
10	Брэндинг, мэдээлэл харилцаа, сурталчилгааны төлөвлөгөө	Нэгдсэн дизайн, хаягжилт, чиглүүлэх тэмдэглэгээ, дижитал мэдээлэл, хэвлэл мэдээлэл, QR систем, олон нийттэй харилцах болон сурталчилгааны зохион байгуулалт
11	Худалдаа үйлчилгээ, хоол үйлчилгээний төлөвлөгөө	Хоол үйлчилгээ, худалдаа үйлчилгээ, үйлчилгээ эрхлэгчдийн сонгон шалгаруулалт, үйлчилгээний стандарт, эрүүл ахуй, үнэ тариф, ногоон үйлчилгээний зохион байгуулалт
12	Оролцогч байгууллага болон visitor service management төлөвлөгөө	Оролцогч байгууллагын бүртгэл, талбай хуваарилалт, нэвтрэх эрх, үйлчилгээний дэмжлэг, мэдээллийн үйлчилгээ, оролцогчдын урсгал, үйчлилгээний мэдээллийн цэг, гомдол шийдвэрлэлтийн зохион байгуулалт
13	Ногоон шаардлага, тогтвортой байдлын төлөвлөгөө	Хог хаягдлын менежмент, хуванцар хэрэглээг бууруулах арга хэмжээ, эрчим хүч, усны хэмнэлт, дахин ашиглалт, байгаль орчны нөлөөллийг бууруулах төлөвлөгөө
14	KPI, тайлагнал болон хяналтын тогтолцооны төлөвлөгөө	Үйлчилгээний түвшин, зочдын сэтгэл ханамж, павильон ашиглалт, техникийн бэлэн байдал, орлого, аюулгүй ажиллагаа, өдөр тутмын тайлагнал болон performance monitoring тогтолцоо
15	Хэрэгжүүлэх үе шатны график	Бэлтгэл ажил, борлуулалт, гэрээ байгуулалт, угсралт, туршилт тохируулга, ашиглалт, өдөр тутмын үйл ажиллагаа, буулгалт, талбай хүлээлгэн өгөх нэгдсэн хугацааны төлөвлөгөө
16	Тайлагнал, хүлээлгэн өгөх баримт бичиг	Орлого-зардлын тайлан, ивээн тэтгэгчийн тайлан, оролцогч байгууллагын тайлан, өдөр тутмын үй

## АРВАН ГУРАВ. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Ногоон бүсийн үйл ажиллагааг дараах үндсэн үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Үүнд:

I үе шат: Төлөвлөлт, концепц, хөрөнгө оруулалт болон үйл ажиллагааны загвар боловсруулах:

Ногоон бүсийн ерөнхий концепц, операторын үйл ажиллагааны загвар, хөрөнгө оруулалт, санхүүгийн бүтэц, орлого-зардлын тооцоо, мөнгөн урсгал, эрсдэлийн удирдлага, ивээн тэтгэгчийн ангилал, оролцооны багц, павильон борлуулалт, үнэ тариф, үйлчилгээний багц, оролцогч байгууллагын үйлчилгээний нөхцөл, брэндинг, мэдээлэл харилцаа, аюулгүй ажиллагаа, ногоон шаардлага, хүний нөөц болон хэрэгжилтийн нэгдсэн төлөвлөгөөг боловсруулна.

II үе шат: Ивээн тэтгэгч, оролцогч байгууллага болон үйлчилгээний экосистем бүрдүүлэх:

Ивээн тэтгэгч, хамтран ажиллагч байгууллага, үндэсний болон олон улсын оролцогч байгууллага, павильон эзэмшигч, үзэсгэлэн гаргагч, худалдаа үйлчилгээ эрхлэгч, нийлүүлэгч, туслан гүйцэтгэгч болон бусад оролцогч талуудыг татан оролцуулах, гэрээ байгуулах, талбай хуваарилах, үйлчилгээний нөхцөл, төлбөрийн бүтэц, нэвтрэх эрх, бүртгэл, павильон ашиглалтын зохион байгуулалт, нийлүүлэгч байгууллагуудын лист бүрдүүлэх, үйлчилгээний бэлтгэл ажлыг хангана.

III үе шат: Захиалгат павильон, дотоод зохион байгуулалт болон ашиглалтын бэлтгэл:

Стандарт болон захиалгат павильоны зураг төсөл, дотоод зохион байгуулалт, брэндиг, дотоод тохижилт, тавилга, тоног төхөөрөмж, дуу дүрс, гэрэлтүүлэг, мэдээлэл холбоо, инженерийн түр хангамж, хэвлэл мэдээлэл, үйлчилгээний бүсүүдийн бэлтгэл, нийлүүлэгч байгууллагуудын зохион байгуулалт, угсралт, суурилуулалт, талбай ашиглалтын уялдаа холбоо, туршилт тохируулга болон ашиглалтын өмнөх шалгалтыг зохион байгуулна.

IV үе шат: Өдөр тутмын үйл ажиллагаа, арга хэмжээ:

Арга хэмжээний хугацаанд Ногоон бүсийн өдөр тутмын үйл ажиллагаа, павильон ашиглалт, үзэсгэлэн, хурал, хэлэлцүүлэг, соёл, олон нийтийн арга хэмжээ, худалдаа үйлчилгээ, хэвлэл мэдээлэл, зочдын үйлчилгээ, оролцогч байгууллагын үйлчилгээ, урсгалын зохион байгуулалт, нэвтрэх зохицуулалт, техник ашиглалт, аюулгүй ажиллагаа, шуурхай удирдлага, тайлагнал болон холбогдох байгууллагуудын уялдаа холбоог нэгдсэн байдлаар удирдан зохион байгуулна.

V үе шат: Буулгалт, хөрөнгө хүлээлцэх болон талбай хүлээлгэн өгөх:

Арга хэмжээ дууссаны дараа павильон, түр байгууламж, тоног төхөөрөмж, дотоод тохижилт, инженерийн түр хангамж болон бусад ашигласан эд хөрөнгийн буулгалт, материалын зөөвөрлөлт, дахин ашиглалт, хөрөнгө хүлээлцэх, тооллого, эвдрэл гэмтлийн үнэлгээ, нөхөн төлбөрийн зохицуулалт, талбайн цэвэрлэгээ, хог хаягдлын менежмент, нөхөн сэргээлт, тогтвортой байдлын тайлан, эцсийн тайлагнал болон талбайг хэвийн нөхцөлд хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулна.

## **АРВАН ДӨРӨВ. ОНЦГОЙ НӨХЦӨЛ**

Гүйцэтгэгч нь Ногоон бүсийн үйл ажиллагааг төрөөс шууд хөрөнгө оруулалтын санхүүжилт шаардахгүйгээр хэрэгжүүлэх боломжит хувилбар, санхүүгийн бүтэц, хөрөнгө оруулалтын эх үүсвэр, орлого бүрдүүлэх механизм, ивээн тэтгэгч болон хамтран ажиллагч байгууллагын оролцоонд тулгуурласан хэрэгжүүлэх санал боловсруулж ирүүлнэ.

- Гүйцэтгэгч нь захиалагчийн баталсан ерөнхий төлөвлөлт, барилга байгууламжийн ажлын даалгавар, зураг төсөл, талбайн зохион байгуулалт, аюулгүй ажиллагааны шаардлага, инженерийн нөхцөл, холбогдох хууль тогтоомж, стандарт, дүрэм журам, олон улсын арга хэмжээний шаардлагыг мөрдөн ажиллана.
- Мөн Ногоон бүсийн хүрээнд хэрэгжүүлэх ивээн тэтгэгч, сурталчилгаа, хамтын ажиллагаа, худалдаа үйлчилгээ, олон нийттэй харилцах болон идэвхжүүлэлтийн аливаа санал, оролцоо, агуулга нь COP17 болон Ногоон бүсийн зорилго, НҮБ-ын үнэт зүйл, байгаль орчны

бодлого, олон улсын байгууллагын шаардлага, дипломат шинж чанар, албан ёсны нэр хүндтэй нийцсэн байна.

- Гүйцэтгэгч нь НҮБ болон COP17 арга хэмжээний албан ёсны нэр, дүрс тэмдэг, нэгдсэн брэндийн бодлого, дипломат болон албан ёсны агуулгатай холбоотой аливаа шийдвэрийг бие даан гаргахгүй бөгөөд холбогдох зөвшөөрөл, баталгаажуулалтыг захиалагч тал хариуцна.
- Түүнчлэн гүйцэтгэгч нь өөрийн болон гэрээт байгууллага, туслан гүйцэтгэгч, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанаас үүдэн гарах осол, гэмтэл, саатал, эвдрэл, аюулгүй ажиллагааны зөрчил, эд хөрөнгийн хохирол, үйлчилгээний доголдол, гуравдагч этгээдэд учирсан хохиролтой холбоотой хариуцлагын зохицуулалтыг санал болон гэрээний төсөлд тодорхой тусгана.
- Гүйцэтгэгч нь оролцогч байгууллага, үйлчилгээ эрхлэгч, ивээн тэтгэгч, хамтран ажиллагч байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо, үйлчилгээний чанар, аюулгүй ажиллагаа, байгаль орчны шаардлага, өдөр тутмын ашиглалтын хэвийн нөхцөлд хяналт тавьж, илэрсэн зөрчил, эрсдэлийг шуурхай шийдвэрлэх зохион байгуулалтыг хэрэгжүүлнэ.
- Саналд тусгагдсан хөрөнгө оруулалт, орлого, зардал, ивээн тэтгэгчийн нөхцөл, оролцогч байгууллагын төлбөр, үйлчилгээний орлого, түрээс, төлбөр тооцоо болон бусад санхүүгийн мэдээлэл нь ил тод, хянах, тайлагнах боломжтой байх бөгөөд захиалагчид тогтмол тайлагнах нөхцөлийг бүрдүүлсэн байна.
- Гүйцэтгэгч нь Ногоон бүсийн үйл ажиллагааны хүрээнд ашиглагдах бүх байгууламж, үйлчилгээ, техник ашиглалт, өдөр тутмын үйл ажиллагааг аюулгүй, хэвийн, тасралтгүй явуулах бэлэн байдлыг хангаж, эрсдэлийн нөхцөл үүссэн тохиолдолд шуурхай арга хэмжээ авах нөөц төлөвлөгөөтэй байна.
- Оператор байгууллага нь Ногоон бүсийн хүрээнд цугларсан оролцогч, байгууллага, үйлчилгээ, бүртгэл болон үйл ажиллагаатай холбоотой мэдээллийн нууцлал, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллах бөгөөд холбогдох мэдээллийг захиалагчийн зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд дамжуулахгүй.
- Гүйцэтгэгч нь хүчтэй салхи, шороон шуурга, аадар бороо, үер ус, эрс хүйтрэл, цахилгаан болон инженерийн хангамжийн доголдол, халдварт өвчин, хорио цээрийн нөхцөл, олон нийтийн эмх замбараагүй байдал болон үйл ажиллагаанд ноцтой нөлөөлж болзошгүй бусад онцгой нөхцөл үүссэн үед хэрэгжүүлэх шуурхай зохицуулалт, үйл ажиллагааны тасралтгүй байдлын төлөвлөгөө, нөөц зохион байгуулалтын арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.
- Мөн онцгой нөхцөл байдлын үед павильон, тайз, олон нийтийн талбай, үйлчилгээний хэсгийн ашиглалтыг хэсэгчлэн эсхүл түр хугацаагаар хязгаарлах, үйл ажиллагааны хуваарьт өөрчлөлт оруулах, оролцогч болон зочдын хөдөлгөөнийг зохицуулах, аюулгүй бүсэд шилжүүлэх, мэдээллийг шуурхай хүргэх зохион байгуулалтыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
- Онцгой нөхцөл байдлын улмаас үүссэн саатал, үйлчилгээний доголдол, үйл ажиллагааны өөрчлөлт, эд хөрөнгийн эрсдэл, хохиролтой холбоотой хариуцлага, мэдээлэл солилцоо, шийдвэр гаргах болон тайлагналын зохицуулалтыг санал болон гэрээний төсөлд тодорхой тусгана.
- Хувийн хэвшлийн оролцогч байгууллагуудын павильоны хэмжээ, зориулалт, үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан талбайн зохион байгуулалтыг харилцан адилгүй төлөвлөж болох боловч павильон бүрийн ашиглалтын доод хэмжээ, урт, өргөн, өндөр

болон талбайн эзлэх хэмжээг ажлын зураг, зохион байгуулалтын төлөвлөгөөнд нарийвчлан тусгана.

- Павильоны хамгийн бага ашиглалтын талбайг зохион байгуулагч талаас баталсан талбайн ерөнхий төлөвлөлт, аюулгүй ажиллагаа, хүн урсгал, үйлчилгээний хүртээмжтэй уялдуулан тогтоож, оролцогч аж ахуйн нэгжүүдэд урьдчилан мэдэгдэнэ.
- Павильон, үзэсгэлэнгийн талбай, үйлчилгээний цэгүүдийн хаягжилт, чиглүүлэх тэмдэг, реклам сурталчилгаа, брендинг, мэдээллийн самбарын байршил, хэмжээ, өнгө үзэмж, гэрэлтүүлэг, материалын шийдлийг олон улсын хурал, үзэсгэлэн зохион байгуулах жишиг, холбогдох хууль, дүрэм, журам, стандартын шаардлагад нийцүүлэн боловсруулна.
- Хаяг, реклам, брендинг нь орчны ерөнхий архитектур төлөвлөлт, нэгдсэн өнгө төрх, аюулгүй байдал, үзэгдэх орчин, хүн урсгалд саад учруулахгүй байх нөхцөлийг хангана.
- Павильон болон үйлчилгээний талбайн үндсэн хаягжилт, чиглүүлэх тэмдэг, реклам сурталчилгааны байгууламжийн дээд өндөр нь ерөнхий төлөвлөлт, аюулгүй ажиллагаа, үзэгдэх орчны шаардлагатай уялдуулан **3.5 метрээс хэтрэхгүй** байна.
- Тусгай зориулалтын, томоохон хэмжээний брендинг, тайз, медиа байгууламж, түр байгууламжийн хувьд өндөр, хэмжээ, байрлалыг захиалагч болон зохион байгуулагчтай урьдчилан зөвшилцөж батлуулна.